

Төрлөөр устгах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь

Батхуягийн АЛТАНГЭРЭЛ*

-
- I. Удиртгал
 - II. Үндсэн хэсэг
 - 2.1. Төрлөөр устгах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар дотоодын практик судалгаа
 - 2.2. Төрлөөр устгах гэмт хэргийн талаар олон улсын практик судалгаа
 - III. Дүгнэлт
 - IV. Санал
-



* Улсын дээд шүүхийн хэргийн хөдөлгөөн, мэдээлэл, судалгааны хэлтсийн судлаач, Хуульч, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант.



Төрлөөр устгах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь

Батхуягийн АЛТАНГЭРЭЛ Улсын дээд шүүхийн хэргийн хөдөлгөөн, мэдээлэл, судалгааны хэлтсийн судлаач, Хуульч, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант.

Хураангуй: Төрлөөр устгах гэмт хэрэг нь тодорхой бүлгийг системтэй устгах зорилготой хүчирхийллийн үйлдэл бөгөөд энэ нь НҮБ-ын 1948 оны "Геноцидийн конвенц"-оор эрүүгийн ноцтой гэмт хэргийн ангилалд хамаарагдаж, хариуцлага ногдуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Гэсэн хэдий ч улс орнуудын хувьд гарч буй маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, эсхүл хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох үүргээ үл биелүүлснээр тус гэмт хэргээс үүдэх хохирлыг улам даамжрах эрсдэлийг нэмсэн харамсалтай үйл явдлууд багагүй гарсан билээ. Хэдийгээр улс орнуудын хувьд Эрүүгийн хуульдаа төрлөөр устгах гэмт хэргийг тодорхойлж, бүх насаар хорих, цаазаар авах ялыг хуульчилж, олон улсын эрүүгийн шүүхүүд, тухайлбал, ICC, ICTY, ICTR нь гэмт хэргийг хожмоо шийдвэрлэж, гэмт этгээдэд хариуцлага ногдуулж, хүн төрөлхтний амьд явах эрхийг хамгаалахад чухал хувь нэмэр оруулсан.

Монгол улсын хувьд эрүүгийн эрх зүйн түүхэн хөгжлийн явцад "төрлөөр устгах гэмт хэрэг" хэмээн албан ёсоор тэмдэглэгдэн үлдсэн тохиолдол байхгүй боловч зарим судлаачид 1937 оны "хэлмэгдүүлэлт"-ийг төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг агуулсан хэмээн үзэх нь бий. Дан ганц хэлмэгдүүлэлт гэлтгүй, сүүлийн жилүүдэд олон улсад зарим судлаачид Коронавируст цар тахлыг төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг агуулж байж болзошгүй хэмээн таамаг дэвшүүлж буй юм. Иймд улс орнууд геноцидийн гэмт хэрэгт хариуцлага ногдуулах хууль эрх зүйн орчноо сайжруулж, Responsibility to Project буюу "Хамгаалах үүрэг" гэдэг зарчмыг хэрэгжүүлэхийн тулд олон улсын хамтын ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай талаар хөндөн судаллаа.

Түлхүүр үг

Хамгаалах үүрэг, төрлөөр устгах гэмт хэрэг, олон улсын гэмт хэрэг, олон улсын эрүүгийн эрх зүй, төрлөөр устгах гэмт санаа

I. УДИРТГАЛ

Олон улсын гэмт хэргүүдээс төрлөөр устгах гэмт хэргийн хувьд Засгийн газрын үйл ажиллагааг тасалдуулах, иргэний нийгмийн үндсийг эвдэн, хүний эрх, эрх чөлөөнд хохирол учруулж, улс гүрнүүдийн эдийн засгийн болон нийгмийн



хөгжилд хөнөөлтэй үр дагавар учруулдгаараа дан ганц нэг улсын асуудал бус тухайн бүсийн, дэлхий нийтийн асуудал болдгоороо ноцтой хохирол, хор уршгийг дагуулдаг.

Олон улсын алан хядах үйлдэл, гэмт бүлэглэлийн өсөлт, насанд хүрээгүй хүмүүсийг улс дамжуулан худалдах, гадаадын иргэдийг нууцаар хил гаргах, экологийн гэмт хэргүүд, компьютер болон теле холбооны хэрэгсэл ашиглахтай холбогдсон гэмт хэргүүд дэлхийн хамтын нийгэмлэгийг түгшээж байсан цаг саяхан.

Олон улсын гэх тодотголтой гэмт хэргийг дотоодын эрүүгийн эрх зүйд тодорхойлсон гэмт хэргээс ялган Академич С.Нарангэрэл "энх тайвныг сахин хангах, хувь хүнийг хамгаалах тулгуур үндэс болсон олон улсын хамтын нийгэмлэгийн амин чухал эрх ашигт бүхэлд нь ач холбогдол бүхий олон улсын эрх зүйн зарчим ба хэм хэмжээг зөрчсөн, хүн төрөлхтний соёл иргэншилд онц аюултай гэмт хэрэг" гэж тодорхойлжээ. Эндээс үзэхэд олон улсын гэмт хэргийн хамгийн гол онцлог шинж нь олон улсын хамтын нийгэмлэгийн амин чухал эрх ашигт ач холбогдол бүхий олон улсын эрх зүйн зарчим ба хэм хэмжээг зөрчсөн, хүн төрөлхтний соёл иргэншилд онц аюултай хэрэг байх явдал юм.

Тэдгээрийн дотроос Геноцид нь олон улсын гэмт хэрэг бөгөөд дэлхийн хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн жигшүүрт гэмт хэргийн нэг юм. Энэ нь үндэстэн, угсаатны, арьс өнгө, шашны бүлгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн устгах зорилготойгоор зориудаар, системтэйгээр устгах явдал билээ.

1948 онд НҮБ-аас Геноцид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай конвенцийг (геноцидийн конвенц) баталсан бөгөөд мөнхүү үр дүнд хүргэсэн шалтгаан нь Дэлхийн II дайны харгислал, ялангуяа Холокост (католик шашинтнууд, польш угсаатнууд, цыганууд, Зөвлөлтийн энгийн иргэд, Зөвлөлтийн цэргийн олзлогдогсод, тахир дутуу хүмүүс, ижил хүйстнүүд, жэновагийн гэрч нар, бусад улс төр, шашны өрсөлдөгчдийг сая саяар нь системтэй устгасныг оруулах нь зүйтэй гэж үзсэн үзэл, үйлдэл) байв.

Түүнчлэн Дэлхийн II дайн дууссанаас хойш төрлөөр устгахтай холбогдсон гэмт хэрэг, цэргийн гэмт хэргүүд гарах болсны улмаас НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрээр 1991 оноос хойш хуучин Югославын нутаг дэвсгэр дээр олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчсөн этгээдүүдийг шүүх Руандагийн нутаг дэвсгэр дээр гарсан төрлөөр устгах гэмт хэрэг, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн бусад ноцтой зөрчлийн төлөө хариуцлага хүлээх Руандагийн иргэдийг шүүх Олон Улсын Шүүхийг тус тус байгуулсан.

Олон улсын хэм хэмжээ, номлолын дагуу геноцид нь ***jus cogens***¹ хэм хэмжээ гэж тооцогддог бөгөөд бүх нийтээрээ геноцидийг хориглох үүргээс татгалзаж үл болно. Геноцидийн зохицуулалтын хэрэгжилтийг Руандагийн Олон улсын эрүүгийн шүүх (ICTR), Хуучин Югославын олон улсын эрүүгийн шүүх (ICTY),

¹ *Jus cogens* буюу албадан хууль гэдэг нь олон улсын заншлын эрх зүйг зохицуулдаг хэм хэмжээний ангилалд хамаарна. Латин нэр томъёог англи хэл дээрх "зайлшгүй норм" гэсэн үгтэй сольж хэрэглэдэг. *Jus cogens* хэм хэмжээ нь бусад хэм хэмжээнээс үндсэн хоёр зүйлээр ялгаатай. Нэгдүгээрт, *jus cogens* хэм хэмжээ нь заавал байх ёстой, хоёрдугаарт заавал дагаж мөрдөх ёстой юм.



сүүлийн үед Олон улсын эрүүгийн шүүх (ICC) зэрэг олон улсын шүүхээр дамжуулан хэрэгжүүлж байна. Хэдийгээр тодорхой эрх зүйн зохицуулалт хүчин төгөлдөр хэрэглэсээр ирсэн хэдий ч улс төр, дипломат болон нотлох баримтын нарийн төвөгтэй байдлаас үүдэн геноцидоос урьдчилан сэргийлэх, хариуцлага ногдуулахад бэрхшээлтэй хэвээр байна.

Монгол Улс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон боловч дотоодын эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг мөн дурдаж болно. Эрх зүйн тус салбар нь олон улсын хамтын ажиллагааны аргагүйдсэн зайлшгүй арга хэмжээ болохын хувьд эрх зүйн үндсэн дээр байнга боловсронгуй болсоор байна.

Төрлөөр устгах гэмт хэрэг Монгол улсад гарч байсан эсэх, тус гэмт хэргийн шинжийг агуулсан байж болохуйц тохиолдлуудад дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ, олон улсад гарсан төрлөөр устгах гэмт хэргүүд, түүний шинжийг агуулсан тохиолдлуудад дүн шинжилгээ хийсэн болно.

Төрлөөр устгах гэмт хэрэг нь манай улсын хувьд хангалттай судлагдаагүй, харьцангуй шинэ салбар бөгөөд энэ талаар эрдэмтдийн гаргасан бүтээл тун ховор байгаа тул дэлгэрүүлэн судлахыг зорьсон болно.

Судлагдсан байдлын авч үзвэл:

Дотоодын бүтээлүүдэд:

Г.Совд, Н.Баатаржав, С.Жанцан; Н.Лхагваа, С.Нарангэрэл, Б.Жаргал, зэрэг эрдэмтэн, судлаач нар өөрсдийн бүтээлүүдээ олон улсын гэмт хэрэг, төрлөөр устгах гэмт хэргийн талаар эрүүгийн эрх зүйн хүрээнд туурвисан номдоо агуулгын хүрээнд дурдсан байдаг бол М.Уянга "Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх асуудалд", Д.Мөнхтуяа "Олон улсын гэмт хэрэг, түүний олон улсын болон дотоодын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал", Д.Гэрэлтөв "Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн ерөнхий асуудлууд ба Монгол улсын үүрэг оролцоо", С.Ариунтуяа "Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх олон улсын хамтын ажиллагаа ба Монгол Улсын холбогдох гэрээнүүд" Б.Баярцэцэг "Үндэсний ба олон улсын эрүүгийн эрх зүй дэх мөнгө угаах гэмт хэрэг" зэрэг судалгааны өгүүлэлд олон улсын гэмт хэргийн талаар дурдсанаар өөрөөр төрлөөр устгах гэмт хэргийн талаар дэлгэрүүлэн судалсан нэг сэдэвт бүтээл, өгүүлэл, нийтлэл байхгүй байна.

Иймд энэхүү өгүүлэлээр олон улсын гэмт хэргийг онолын үүднээс тодорхойлох, тэр дундаа төрлөөр устгах гэмт хэргийн элемент, шинжийг тодорхойлж сүүлийн үеийн илрэн гарах хэлбэрүүдийг дэлгэрүүлэхийг зорьсон юм. Ийнхүү олон улсын гэмт хэргийн төрлөөр устгах гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүнийг нарийн тодорхойлсны үндсэн дээр тэдгээрийн олон улсын эрх зүйн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийж, дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйг харьцуулснаар энэхүү өгүүллийн онцлог илэрнэ хэмээн судлаачийн зүгээс үзэж байна.



II. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1 Төрлөөр устгах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар дотоодын практик судалгаа

Монгол Улсын хэлмэгдүүлэлт ба төрлөөр устгах гэмт хэрэг

Хэлмэгдүүлэлтийг төрлөөр устгах гэмт хэрэг хэмээн үзэхэд төрлөөр устгах гэмт хэргийн хэд хэдэн шинжийг агуулсан байхыг шаардана. Хамгийн гол нь тодорхой бүлэг хүмүүсийг устгах зорилгоор хийсэн үйлдэл байх ёстой. Монгол улсын хэлмэгдүүлэлтийн хувьд 2 төрлийн бүлэг хүмүүсийг устгах зорилго бүхий үйл ажиллагаа өрнөсөн нь түүхийн хуудаст тэмдэглэгдэн үлджээ. Үүний нэг нь 1.Шашны холбогдолтойгоор лам нарыг устгах үйл ажиллагаа бол нөгөө нь 2.Улс төрийн сэхээтнүүдийг хоморголон устгах үйл ажиллагаа юм.

1921–1937 он хүртэлх арван зургаан жилийн хугацаанд монголын түүхэнд хувьсгалт шинжтэй олон үйл явдал болж өрнөсөн. Үзэл баримтлал, хөгжлийн чиг хандлагын зөрчлөөс үүдэн хувьсгалт төрд тэрсэлсэн хэргээр хамтран зүтгэгчдээ ганц нэг бүхэл хэсгээр цаазлан хороож хөрөнгө тэгшитгэх нэрээр ард иргэдийнхээ эд хөрөнгөнд халдаж, Коминтерныг хүсэл зоригийн хүрээнд төрийн эргэлт хийсэн эгзэгтэй он жилүүд байв. Энд Шашин сүм хийдийн талаарх И.В.Сталины байр суурийг авч үзэх нь зүйтэй². Уг асуудлыг ойлгох түүний үзэл ихээхэн зөрчилтэй бөгөөд бүхэлдээ юуны урьд лам нарыг хувьсгалын эсэргүү хэмээн үзэхэд үндэслэж тэдний эсрэг хүч хэрэглэхэд чиглэгджээ. Энэ нь "Зүүний" нугалааны үед лам нар, сүм хийдийн асуудлыг завхруулснаас эхлээд "Лхүмбийн хэргээр" дамжин 1930-аад оны эцсээр хорь шахам мянган лам нарыг хэлмэгдүүлсэн завхрал 1940-өөд онд лам нарын сүүлчийн хэсгийг хороосон явдлуудаар үндсэндээ дууссан үйл явдал байсан³.

Коминтерны сүм хийдийн талаарх бодлого маш нарийн явагдсан. Тэд эхлээд лам нарын эд хөрөнгийг хураах тогтоол гаргаж ард амьдрал руу өөрсдөө ороход нь түлхэж байв. Тухайн үед ардын засгаас гаргасан тогтоолд "Феодал" хэмээгчдийн хөрөнгийг хураах ажилд 100 ба түүнээс дээш хувийн хөрөнгө 920 гаруй өрхийг хамарч, тэднээс 729 нь тухайн үеийн ханшаар 5.2 сая гаруй төгрөгийн үнэ бүхий мал ба үл хөдлөх хөрөнгөө хураалгажээ. Түүнчлэн уг тогтоолд: "Эдгээр этгээдийн хөрөнгийг шууд хурааж, өөрийн аж амьдралыг сайжруулах үндсэн хөрөнгө болговоос зохимуй" хэмээгээд феодалын хөрөнгийг хэрхэн хураах зааврыг баталсан байна. 100 хувь хөрөнгө нь тэр үеийн ханшаар бол 3000 төгрөг, эсхүл 60 тэмээ, эсхүл 100 адуу, эсхүл 100 үхэр, эсхүл 500 хоньтой тэнцэж байжээ.⁴

Энэ тухайн Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга З.Шинжээ хэлсэн үгэндээ, уг үйл явдлыг феодал лам нартай эсэргүүцэн тэмцэх явдлын дотор анх тэргүүнээ эхлэн явуулсан нэгэн чухал хэрэг хэмээн дүгнээд энэ хэргийг гүйцэтгэн

² Соводсүрэнгийн Нарангэрэл, Монголын Их Хэлмэгдүүлэлт, Монголын 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн түүхэн явц, түүний үр дагавар, архивын баримт материалд тулгуурласан судалгаа, 2008, 56 дах тал

³ Сүхбаатарын Эрдэнэболд, "Монголын түүхэн хэлмэгдүүлэлт ба хүний эрх", Хэлмэгдүүлэлтийн хүний эрхийн зөрчил, түүхэн үр дагаврын талаар судалсан бүтээл, 2010, 84 дэх тал

⁴ Монголын түүх 5-р боть, 171



явуулахад 427 феодал ба хутагт хувилгаад, 302 түшмэдээс 4793392 төгрөг 89 мөнгөний үнэтэй мал 358952 төгрөг 36 мөнгөний үнэ бүхий зүйл ба 70225 төгрөг 50 мөнгөний үнэтэй үл хөдлөх хөрөнгө бүгд нийлсэн 5222567 төгрөг, 72 мөнгөний үнэтэй юмсыг хураасан, хураасан мал ба хөрөнгө зоориноос 1560436 төгрөг 70 мөнгөний үнэ бүхий зүйлүүдийг ядуу ардуудад шилжүүлэн өгснөөс гадна бусад мал ба хөрөнгө зоорийг нь 130 хамтралуудад хуваан өгсөн гэж тэмдэглэжээ.

Тухайн үед бурхан шашныг шүтэх үзэлд Монголчууд хүчтэй ууссан байсан бөгөөд энэ тухай "Намын доторх зүүн жигүүрийнхний эрмэлзэх санал"-д "Шашин лам нарын элдэв идэвх хөдөлгөөн улс төрийн явуулгыг устгах тухай" гэсэн заалт олныг хөндөж Дамбадорж хэлэхдээ "Тус Монголын одоогийн байдлыг үзвээс харьяат олон ард түмэн бурхан шашныг итгэж сүсэглэх явдал гүн зузаан учир хэрэв хөдөө хотын олон ард дор бурхан шашин хэрэг үгүй хэмээн дэлгэрүүлэх дор бэрх юм. Бидний намын түмэн илүү гишүүдийн дотор бурхан шашныг тахих сүсэглэхгүй этгээд цөөхөн гарах буй за" хэмээжээ. Харин Коминтерны зүгээс лам нар танай улсын дайсан, лам нараа устга гэдэг үгийг үргэлж тулгаж байв. Зөвлөлтийн дотоод явдлын яамны сургагч байсан Чибисов БНМАУ-д айлчлаад буцахдаа /1934 оны 12 сарын 31/ БНМАУ-ын дотоодыг хамгаалах газрын дарга Д.Намсрайд захиас болгож "Сталин урьд хэлэхдээ лам нар цөмөөрөө эсэргүү этгээд мөн. Гагцхүү тус орон нутгаас урвасан хэмээн илээр олны өмнө шийтгэх хэрэгтэй. Дээд лам нар чинь байдал тайван байна. Иймд үүнийг хэвээр тайван байлгах явдалгүй. Лам нарын талаар цохилт өгөх хэрэгтэй" гэжээ.

Энэхүү Сталины уг санаа 1934–1936 онд ерөнхий сайд П.Гэндэн, А.Амар нартай Москвад хийсэн уулзалтын үеэр түүний хэлсэн үгнээс нотлогдож байна. Сталин 1934 онд П.Гэндэн, Р.Мэнд нартай уулзахдаа лам нарын талаар "тойрон бүслэх"⁵ арга хэрэглэхийг зөвлөжээ. Түүнчлэн Коминтерны сургагч нар Сталины даалгавраар зориуд сүм хийд лам нарын эсрэг турхирч байсан тухай сургагч М.Амагаеваас Ф.Ф.Петровт илгээсэн захидлаас харж болно. Уг захидлын хэсгээс авч үзвэл "... тухайлбал бүх материалыг нарийвчлан судлах, лам нарын дунд зохиох намын чиг шугам ба төлөвлөгөөг бүрэн гүйцэд зохицуулах хүртэл лам нарын асуудлаар тавих илтгэлийг зориуд хойшлуулж байв. Одоо Төв хороонд лам нарын асуудлаар нийтлэг ойлголт хандлагатай болж чадсан бөгөөд төв хорооны эгнээн дотор энэ асуудлаар ямар нэгэн зөрөлдөөн гарна хэмээн эмээх зүйлгүй боллоо. Таны өгсөн удирдамжуудыг лам нарын асуудлаар намаас явуулах бодлогын үндэс болгосон юм"⁶ хэмээн бичсэн байна.

Ийнхүү шашны бүлэг буюу лам нарыг устгах зорилго бүхий үйл ажиллагаа өрнөсөн. Коминтерн нь дан ганц лам нартай тэмцэж байсангүй бас монголын нийгмийг удирдаж байсан төрийн зүтгэлтнүүдтэй тэмцэж байсан. Богдын тухай асуудлыг авч хэлэлцэхэд Богдыг хүлээн зөвшөөрөхгүй гэж 12 гишүүн саналаа өгч байхад улс төрийн энэ маш чухал асуудлаар 4 гишүүн санал өгөхөөс түдгэлзсэнийг тэмдэглэх нь зүйтэй" хэмээн бичсэнийг үзвэл тус намын шашин хийдтэй холбоотой шийдвэрийг байнга коминтернд мэдээлж, тэр байтугай намын дотор нэгдмэл байх байр суурьгүй гишүүдийг дурдаж байсан байна. Монгол Улсын

⁵ (Үнэн сонин, 1990)

⁶ Төмөрдөшийн Баярхүү, "Улаан террор: Монголын Улс төрийн хэлмэгдүүлэлт", 2009, 65 дах тал



цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын төлөөлөгчид Москвад айлчлах үеэр 1937–1941 онд Москвагийн ойролцоох Бутовогийн Коммунаркад улс төрийн хилс хэргээр хэлмэгдэж цаазлагдсан хүмүүсийн баримттай танилцсан бөгөөд түүний дотор 30 гаруй монгол хүн байсан байна.

Хилс хэргээр хэлмэгдсэн эдгээр иргэдийн дотор БНМАУ-ын Ерөнхий сайд, БНМАУ-ын бага хурлын дарга болон яамдын сайд, МАХН-ын хариуцлагатай ажилтнууд багтаж байсан. Тэдгээрээс 25 нь бага боловсролтой, 5 нь дунд, 2 нь бүрэн бус дунд, 3 дээд боловсрол эзэмшсэн хүмүүс байсан хэмээн түүхийн эх сурвалжуудад тэмдэглэгджээ. Хэлмэгдэгсдийн хамгийн залуу нь 1915 онд төрсөн бөгөөд 26 насандаа цаазлагдсан Ж.Гэндэн, хамгийн ахмад нь 1887 онд төрж, 54 насандаа мөнх бусыг үзсэн А.Амар байна. Нийт 420 орчим хэлмэгдсэн Монгол иргэн байна гэсэн мэдээ байдаг.

Хууль ёсыг зөрчиж 1932 оны хавар гэхэд зөвхөн төвийн хорих газруудад 5191 хүн хоригдоход хүрсэн байна. Тэдгээрийн 4610 хүний хэргийг хувьсгалын 11 жилийн ойгоор хэрэгсэхгүй болгож хуваагдсан хөрөнгийг нь буцаан өгөхөөр шийдвэрлэжээ.⁷ Гэвч эдгээр хүмүүсийн хувь заяа дотоодын хамгаалах газрын хяналтад байх болж хожим дахин баривчлагдах үндэс болжээ.

Их хядлагаар насанд хүрсэн 5 хүн тутмын 1 нь буюу 10 хүнээс 2 нь баривчлагдаж байсан бол Монгол буриадуудын хувьд 1937–1938 онд насанд хүрсэн эрэгтэй буриадуудын 10 хүн тутмын 9 нь баривчлагдаж, баривчлагдсан 10 буриад тутмын мөн 9 нь буудуулсан байна. Тийнхүү монголын буриадууд бол Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтэд хамгийн ихээр өртсөн зоны нэг юм.

Монголын буриад нарын ихэнх нь оршин суудаг Дорнод, Хэнтий хоёр аймаг 1934 оны тоогоор 17,4 мянган буриадтай байснаас насанд хүрсэн эрэгтэй нь 6000 хүрэхгүй байсан боловч 5368 нь баривчлагдан хэлмэгджээ. Наашлаад Сэлэнгийн буриадын хувьд гэвэл Сэлэнгэ аймагт буриадууд 1920–30-аад онд ихэнхдээ Ерөө голын буриад хошуу нэртэйгээр одоогийн Ерөө сумаар оршин суудаг байсан ба 1937–38 онд насанд хүрсэн бараг бүх эрэгтэйчүүд нь баривчлагджээ.

1921 оны намар түвд лам нар Богдын дэмжлэг, Японы туслалцаатайгаар ардын хувьсгалт засгийг түлхэн унагах гэж байна гэсэн зохиомол хэргийг сэдэж, саж лам Жамъянданзан тэргүүтэй олон түвд лам хуврагуудыг “Саж ламын хэрэг” гэгчээр хэлмэгдүүлэн баривчилсан байна. Харин түүнээс хойш буюу 1922 онд Бодоо, Чагдаржав нарын бүлэг, буриад Очиров, Туванов нарын бүлэг, 1924 онд Данзан, Баваасан нарын бүлэг гэх мэтээр зохиомол хэргийн хэлмэгдүүлэлтүүд жил бүр явагдсаар 1937–40-өөд онд бүр гаарч, хэдэн арван мянган гэмгүй хүнийг баривчлан шийтгэж, тэдний 3/4-г нь буудан алсан байдаг.

Монгол дахь их хэлмэгдүүлэлт гэж ЗХУ-ын Дотоод Хэргийн Ардын Комиссарын газрын /НКВД/ орлогч дарга генерал М.Фриновский, Батлан Хамгаалахын Ардын Комиссарын газрын орлогч дарга генерал Д.Смирнов, Монголд суух бүрэн эрхт шинэ элчин төлөөлөгч С.Миронов нар манай НТХ, Засгийн газарт ч хэлж мэдэгдэлгүйгээр 1937 оны 8-р сарын 26-нд Улаанбаатарт гэнэт хүрэлцэн ирж, Фриновский нь дайчлан баривчилж устгах шаардлагатай гэх манай 115

⁷ Дэмбэрэлийн Өлзийбаатар, “Монголчууд: Хэлмэгдүүлэлтийн эрин үе”, 2007, 59 дэх тал



хариуцлагатай ажилтан-сайд, дарга нар, цэргийн удирдлагуудын "Заговор" /Хуйвалдаан/ нэртэй нэрсийн жагсаалтыг 1937 оны 8-р сарын 28-нд Х.Чойбалсанд гардуулж, Х.Чойбалсан нь уг нэрсийн жагсаалтаас 65 хүнийг нь 9-р сарын 10-ны шөнө дайчлан баривчилснаар эхэлж, гүтгэн гүжирдэж хоморголон баривчилдаг, эрүүдэн шүүж, худал хэрэг тулган хүлээлгэдэг, үй олноор нь хоморголон алж устгадаг фашист үйл ажиллагааг хэлдэг.

1933 онд "Японы тагнуулын хэрэг" буюу "Лхүмбийн хэрэг" гэдэг зохиомол хэргээр ганц жилд буриад голдуу 537 хүнийг баривчилж, фашист арга хэрэглэн хэрэг хүлээлгэж 317 хүнийг шийтгэхдээ 60-ыг нь буудан алах, 257-г нь янз бүрийн хугацаагаар хорих ялаар шийтгээд, бас 126 хүнийг Оросын Тундр руу зөвхөн ялтангуудаар хийлгэдэг хортой, хүнд ажил хийлгэхээр цөлж байснаас гадна лам нарыг барьж устгах зорилгоор зохиомлоор бий болгосон Ёнзон хамбын хувьсгалын эсэргүү "Төв" гэдэг бүлгийн хэрэг гэгчид холбогдуулан 1937 оны хавар уг бүлгийн удирдагчид гэх Ёнзон хамба Лувсанхаймчиг, дэд хамба Дамдин, Монгол дахь тамгатай 13 хутагтаас үлдээд байсан сүүлчийн нь хутагт болох өндөр настай Манзушир хутагт Цэрэндорж нарын 23 том ламыг баривчилж, тэдний "хэргийг" 1937 оны 10-р сарын 4-7-нд Төв театрт "олны" өмнө шүүн таслахдаа 19-д нь буудан алах ял ноогдуулсан байна.⁸

Дээрх хэлмэгдүүлэлтийн зорилгыг төрлөөр хоморголон устгах хэмээн тодорхойлоход төвөгтэй. 1948 оны Геноцидын гэмт хэргийг таслан зогсоох ба шийтгэх тухай конвенц батлагдсан бөгөөд уг олон улсын баримт бичигт төрлөөр устгах гэмт хэргийн зорилгыг "үндэс, угсаа, арьс үндэс буюу шашин шүтлэг нэгтэй бүлэг хүнийг бүхэлд нь буюу хэсгийг нь устгах зорилгоор үйлдсэн" гэмт хэрэг хэмээн тодорхойлсон. Төрлөөр устгах гэмт хэргийн зорилго нь зөвхөн хүмүүсийг устгах биш, харин нэг бүлэг хүмүүсийг бүрмөсөн устгах бөгөөд энэ нь эдгээр хүмүүсийн сайн сайхныг устгах болон түүх, соёл, шашин, амьдралын хэв маягийг устгах зорилгыг давхар агуулж байдаг. Харин хэлмэгдүүлэлтийг зөвхөн лам нар болон сэхээтнүүдийг устгасан үйлдлээр нь төрлөөр устгах гэмт хэрэг хэмээн үзэх боломжгүй байна. Учир нь хэлмэгдүүлэлт нь тухайн бүлэг хүмүүсийн шашин шүтэх явдлыг зогсоох, иргэдийн итгэл үнэмшлийг бууруулах зорилгоор эдгээр бүлэг хүмүүсийг бүрэн устгах бус, эдгээр хүмүүсийн хувь заяаг дордуулан устгах зорилготой байсан. Түүнчлэн тухайн хүмүүсийн дэлгэрүүлж байсан соёлыг тодорхой бүлэг хүмүүсийн хувьд бус нийт ард түмний дотор түгээн дэлгэрүүлэх явдлыг зогсоох зорилготой байсан нь төрлөөр устгах гэмт хэргийн гэмт санаа буюу зорилгыг мөн л үгүйсгэж байна. Өөрөөр хэлбэл хэлмэгдүүлэлт нь тодорхой нийгмийн бүлгийг устгах гэхээс илүүтэй улс төрийн зорилготой байсан учраас төрлөөр устгах гэмт хэргийн тодорхойлолтоос хальсан гэж үзэж болно.

Хэлмэгдүүлэлт нь улс төрийн зорилгоор, зөвлөлт засгийн дарангуйлагчдын гаргасан шийдвэрийн дагуу гүтгэн яллах, хүчээр устгах, нийгэмд нөлөө бүхий хүмүүсийг устгах зорилготой байсан боловч бүлэг хүмүүсийг устгах буюу төрлөөр устгах зорилгоор хийсэн үйлдэл гэж үзэх боломжгүй. Гэхдээ энэ үйл явдлыг төвлөрсөн, хүчирхийлэлтэй, хүний эрхийг зөрчсөн үйлдэл гэж үзэх нь зүй бөгөөд олон хүн эдгээр үйлдлээс хохирч, амиа алдсан юм.

⁸ Дамдиний Дашдаваа, "Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтэд буриад зон өртсөн нь" Буриад судлал, №1, 2008, 47 дахь тал.



Коронавируст цар тахал ба төрлөөр устгах гэмт хэрэг:

Дэлхий нийтийн хүрээнд Ковид-19 цар тахал олон сая хүний амь насыг авч одон, эдийн засагт хүнд цохилт өгч, нийгэмд томоохон өөрчлөлтүүдийг бий болгосон аюулт үзэгдлийн нэг яах аргагүй мөн билээ.

Олон улсын эрх зүйгээр улс орнууд иргэддээ хандах хандлагыг зохицуулдаг. COVID-19 цар тахлын үед хүний эрхийн гурван салбар онцгой ач холбогдолтой байв. Улс орнууд цар тахалд үр дүнтэй хариу өгөхгүй байсан нь вирусээр халдварлаж эсвэл нас барсан хүмүүсийн амьд явах эрх, эрүүл мэндийн эрхийг зөрчсөн байж болох эсэхийг авч үзнэ. Мөн зарим улс орнууд цар тахлыг иргэний болон улс төрийн эрхийг хязгаарлах үндэслэл болгосон эсэхийг- жишээлбэл, сонгуулийг хойшлуулах, улс төрийн эсэргүүцлийг хориглох зэргийг авч үзэж, ингэснээрээ хүний эрхийн үүргээ зөрчсөн эсэхийг шинжилдэг.⁹

Олон Улсууд өөрийн харьяаллын дагуу хүмүүсийн COVID-19 цар тахлын үеийн аюулгүй байдал, нэр төртэйгөөр амьдрах боломжийг хангаж чадаагүй.¹⁰

Америк болон Европын хүний эрхийн конвенцуудад амьд явах эрхийг баталгаажуулж, зөвхөн хууль ёсны шүүхийн шийдвэрийн дагуу л амьд явах эрхийг хязгаарлаж болохыг заасан.¹¹

Судлаачид төрийн үйлдэл эсвэл үл тоомсорлол нь энгийн иргэдэд хор хөнөөл учруулж байгаа тохиолдолд, хэрэв зориудын үл хайхрал, ялгавартайгаар эмчилгээний тусламжийг хязгаарлавал онолын хувьд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, тэр дундаа устгах гэмт хэрэгт хамаарах боломжтой гэж тэмдэглэсэн байна.

International Human Rights хэсэгм: Төрийн үүрэг, хүний эрхийн хамгаалалт, цар тахлын үед тодорхой бүлгийг зориуд хамгаалахгүй орших нь олон улсын эрх зүйн зөрчил болохыг дурджээ.

НҮБ-ээс батлан гаргасан "Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц"-д төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг "үндэс, угсаа, арьс үндэс буюу шашин шүтлэг нэгтэй бүлэг хүнийг бүхэлд нь буюу хэсгийг нь устгах зорилгоор үйлдсэн (a) бүлгийн гишүүдийн амь насыг хороох; (b) бүлгийн гишүүдийн бие махбод, сэтгэцэд ноцтой гэмтэл учруулах; (c) бүлгийг бүхэлд нь буюу түүний хэсгийг бүрэлгэн устгахад чиглэсэн амьдрал, ахуйн нөхцөлийг санаатайгаар бий болгох; (d) бүлгийн дотор төрөлт зогсооход чиглэсэн арга хэмжээ авах; (e) хүүхдүүдийг нэг бүлгээс нөгөөд хүчээр шилжүүлэх зэргийг хамруулан ойлгохоор заажээ.

Өөрөөр хэлбэл төрлөөр устгах гэмт хэрэг нь санаатайгаар бүлэг хүмүүсийг устгах зорилгоор хүнийг алсан, эсхүл хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан, эсхүл төрөлтийг хүчээр зогсоосон, эсхүл хүүхдийг бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан, эсхүл амьдралын өөр нөхцөл бий болгох

⁹ Oona A. Hathaway, Preston J. Lim, Alasdair Phillips-Robins, Mark Stevens "The Covid-19 Pandemic and International Law", (Cornell International Law Journal, 54, No. 2, 2021) p.171

¹⁰ Hathaway et al., supra note [1], at 171.

¹¹ Hathaway et al., supra note [1], at 172



замаар тэднийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн устаж үгүй болоход хүргэсэн, эсхүл хүчээр сураггүй алга болгосон идэвхтэй үйлдлүүд байх ёстой.

Харин цар тахлыг төрлөөр устгах гэмт хэрэг эсхүл гэмт хэргийн шинжтэй үйлдэл хэмээн үзэх боломжгүй байна.

Зарим улс орнуудад Ковид-19-ийн эсрэг хэрэгжүүлсэн хатуу хөл хорио, эмнэлгийн системийн ялгаварлан гадуурхалт, мөн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой асуудлууд нь тодорхой бүлгүүдэд ялгавартай нөхцөл байдал үүсгэсэн нь төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг мөн л агуулаагүй байна. Ялангуяа буурай орнууд, эмэгтэйчүүд, өндөр настнууд эсвэл аль нэг угсаа, арьсны өнгө бүхий бүлэг хүмүүсийн амьдралд гарсан ялгаварлан гадуурхалт нь хүний эрхийн зөрчил байж болох ч судлаачид энэ нь төрлөөр устгах гэмт хэрэг гэхээс илүүтэйгээр хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн шинжийг агуулж байж болох юм хэмээх санааг ч дэвшүүлсэн байна.

Эндээс үзвэл Коронавируст цар тахал нь төрлөөр устгах гэмт хэргийн субъектив талын шинжийг үл хангаж байгаа буюу зорилго болон гэмт санаагаараа төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг агуулахгүй байна.

2.2 Төрлөөр устгах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар олон улсын практик судалгаа

Руандагийн жишээ төрлөөр устгах гэмт хэргийн тохиолдол болох нь:

Руандагийн геноцид 1994 оны 04 дүгээр сарын 07-ноос 07 дугаар сарын дунд хүртэлх гурван сарын хугацаанд болж, 800,000 орчим хүний амь үрэгдсэн аймшигт үйл явдал юм. Энэхүү төрлөөр устгах гэмт хэрэг нь Руандагийн үндэстэн хоорондын зөрчилдөөнөөс үүдэлтэй бөгөөд голлон химиэс (Hutu) гаралтай хүн ам тутси (Tutsi)¹² үндэстэн рүү халдан довтолсон явдал байв.¹³

Тус гэмт хэрэг үүссэн шалтгаан нь түүхэн үйл явцын туршид үүссэн арьс, үндэс угсааны ялгаа, колонийн дараах улс төрийн хямрал хэмээн судлаачид үздэг. Эдгээрийг дэлгэрүүлэн авч үзвэл Бельгийн колонийн үед (1916–1962 он) Руандагийн хүн амыг Тутси, Хими, Тва (Twa) гэсэн гурван үндэстэн болгон ангилсан. Тутси нар мал аж ахуй эрхэлдэг, бусад үндэстэнтэй харьцуулбал баян чинээлэг, гол төлөв удирдах албан тушаал эрхэлдэг хүмүүс байв. Харин Хими нар олонх боловч тариалан эрхэлдэг, доод түвшний ажлуудыг хариуцдаг байсан. Бельгийн колонийн бодлого нь Тутси нарыг бусдаас илүүд үзэж, нийгэмд гүнзгий хагарал үүсгэсэн нь хожмоо 1962 онд Руанда тусгаар тогтносны дараа хими үндэстэн улс төрийн эрх мэдэлд гарч, тутси нарын эсрэг ялгаварлан гадуурхах бодлого хэрэгжүүлсэн нь энэ үйл явдлын эхлэл болсон.

Улмаар 1990 онд тутси цагаачдаас бүрдсэн Руандагийн эх орончид бослого гаргаж, улс оронд иргэний дайн дэгдээсэн. Ийнхүү дайн дэгдээсний дараа 1994 оны 04 дүгээр сарын 06-нд Руандагийн ерөнхийлөгч Жувеналь Хабьяриманагийн онгоц сөнөсөн явдал нь Руандагийн хэмээн нэрлэгдсэн төрлөөр устгах гэмт

¹² Human Rights Watch, *Bosnia and Herzegovina: A Human Rights Overview*, Human Rights Watch, 1994, 50

¹³ United Nations, *Report of the Commission of Experts Established Pursuant to Security Council Resolution 780 (1992)*, 1994, 100–250



хэрэг эхлэх дохио болсон. Уг үйл явдлыг хими үндэстний удирдлагууд тутси нарыг буруутган, тутси нарыг үндсээр устгах ажиллагааг эхлүүлсэн. Түүнчлэн Радио Телевизион Мил Колины (RTLM) зэрэг хими үндэстний хэвлэлүүд тутси нарыг "хортон шавьж" гэж нэрлэж, устгахыг уриалсан нь аллагыг дэвэргэхэд гол үүрэг гүйцэтгэсэн.

Ийнхүү төрлөөр устгах гэмт хэрэг эхэлсний үр дүнд гурван сарын дотор тутси үндэстэн болон тэднийг дэмжигч хими хүмүүсийг системтэйгээр устгаж, эмэгтэйчүүдийг олноор нь хүчирхийлж, хөнөөсөн. Эл үйл явдлын дараагаар 2 сая гаруй хими үндэстэн хөрш орнууд руу дүрвэсэн. Руандагийн эх оронч фронт (RPF)¹⁴-ын зэвсэгт хүчин 1994 оны 07 дугаар сард нийслэл Кигалийг эзэлж, тус төрлөөр устгах гэмт хэргийг зогсоосон. RPF-ын удирдагч Пол Кагаме нь Руандаг улсын шинэ засгийн газрын тэргүүн болсноор эл үйл явдал зогссон гэж дүгнэж буй.

Уг төрлөөр устгах гэмт хэргийн үед дэлхий нийт болон НҮБ шийдэмгий арга хэмжээ авч чадаагүй. Энэ нь олон улсын хамтын нийгэмлэгт гүнзгий харамсал үлдээсэн. Руандагийн геноцид нь хүний эрхийн зөрчил, үндэстний эв нэгдэл, хүлцэл, уучлалын үнэ цэнэ, төрлөөр устгах гэмт хэргийн эсрэг дэлхийн хамтын ажиллагааны чухал сургамж болсон. 1994 онд Руандаг улсын геноцидын үеэр хийгдсэн аллага, хүчирхийлэлд холбогдсон зарим хүмүүс АНУ-д орогнож байсан. Тэднээс АНУ-д орогнож байсан Фелисиен Кабуга нь Руандаг улсыг геноцидын үеэр санхүүжилтээр хангаж, суртал ухуулга дэмжсэн гэж үзэгддэг. Тэрээр олон жил АНУ болон бусад улс орнуудад орогнож байсан бөгөөд сүүлд баривчлагдаж, Олон улсын эрүүгийн шүүхийн өмнө хариуцлага хүлээсэн бол бусад Руандаг улсын хэрэгтнүүд АНУ-ын цагаачлалын хуулиар баривчлагдаж, өөр улсад шилжүүлэн шүүх эсвэл АНУ-аас албадан гаргаж байсан.

Боснийн дайн төрлөөр устгах гэмт хэргийн тохиолдол болох нь:

Боснийн дайн нь 1992–1995 оны хооронд болсон бөгөөд Югославын задралын үеэр Босни ба Херцеговинад дэгдсэн аймшигт зэвсэгт мөргөлдөөн юм. Уг дайн нь үндэстэн, шашны ялгаанаас үүдэлтэй төдийгүй улс төр, газар нутгийн хяналтыг тойрсон сөргөлдөөн байсан. АНУ-ын хувьд хуучин Югославын нутаг дэвсгэр дээр гарсан геноцидийн хэргийг олон улсын түвшинд шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, Сребреница зэрэг газарт гарсан хоморголон устгалын үйлдлийг шүүхэд шаардлагатай нотлох баримтыг цуглуулахад тусалсан.¹⁵

1990-ээд оны Балканы хойгийн дайны үеэр Боснид үйлдэгдсэн геноцидын гэмт хэрэгт холбогдсон зарим хүмүүс АНУ-д дүрвэн орогносон байсан бөгөөд АНУ-ын Хууль зүйн яам болон Холбооны мөрдөх товчоо (FBI) хамтран Боснийн дайны гэмт хэрэгтнүүдийг АНУ-д оршин сууж буйг илрүүлэх ажиллагаа явуулж, тэднийг шүүх хуралд оролцуулахад дэмжлэг үзүүлсэн¹⁶.

¹⁴ International Criminal Tribunal for the former Yugoslavia, *Case Summary – Ratko Mladić and Radovan Karadžić* Publication: ICTY, 2017, Online

¹⁵ International Criminal Tribunal for the former Yugoslavia (ICTY), *Case Summary: Ratko Mladić and Radovan Karadžić*, ICTY Official Website, 2017, www.icty.org

¹⁶ International Criminal Court, *Srebrenica: A Crime Against Humanity*, International Criminal Court, 2011, 1–120



Югославын социалист холбоот улс 1990-ээд оны эхээр задрах үед үндэстэн хоорондын зөрчилдөөн хурцадсан бөгөөд Сербүүд, хорватууд, босниакууд (мусульманчууд) гэсэн үндэстний бүлгүүд өөрийн газар нутаг, эрх мэдлийг бататгахыг эрмэлзсэнээр уг үйл явдлын эхлэл тавигдсан.

Учир нь 1992 онд Босни ба Херцеговина Югославаас тусгаар тогтнох санал асуулга явуулж, олонх нь тусгаар тогтнолыг дэмжсэн. Гэвч Сербүүд үүнийг эсэргүүцэж, Боснийн Сербүүдийн удирдагчид тус улсыг Югославын үлдээхийг шаардан дайн эхлүүлсэн. Улмаар Босни дахь мусульман босниакууд, католик хорватууд, үнэн алдартны шашинт сербүүд хоорондын шашин, үндэстний ялгаа зөрчилдөөнд хүргэсэн.

Улмаар Сербийн хүчнүүд Боснийн нутаг дэвсгэрийн ихэнх хэсгийг эзлэхийг оролдож, бусад үндэстнийг хөөж гаргахыг зорьсон бөгөөд Этник цэвэрлэгээний тактикуудыг ашиглаж, босниак болон хорват иргэдийг хоморголон устгасан. Хамгийн алдартай жишээ нь **Сребреницагийн аллага** бөгөөд 1995 онд 8,000 орчим босниак эрэгтэйчүүдийг хөнөөсөн.

Уг дайны үеэр 100,000 гаруй хүн амь үрэгдэж, 2 сая орчим хүн уугуул нутгаасаа дүрвэж, олон зуун хүн хүчирхийлэл, аллагад өртсөн. Тус зөрчилдөөнийг НҮБ, НАТО зогсоохыг оролдож, НҮБ-ээс энхийг сахиулагчдыг байршуулсан ч үр дүн муутай байсан.¹⁷ Үүний дараагаар НАТО-гийн зүгээс 1995 онд Сербийн хүчнүүдийг эсэргүүцэн агаарын цохилт өгч, дайныг намжаахад хувь нэмэр оруулж, 1995 оны 12 дугаар сард **Дейтон хотын энхийн хэлэлцээр** байгуулснаар дайн албан ёсоор төгссөн. Уг хэлэлцээрийн үр дүнд Босни ба Херцеговина нь хоёр автономит бүсэд хуваагдан **Боснийн Сербүүдийн** Бүгд Найрамдах Улс, Боснийн Холбооны Бүгд Найрамдах Улс (босниак, хорватуудын нутаг) болон 2 хэсэгт хуваагдсан.

Сребреницагийн аллага (Босни ба Херцеговина, 1995 он)

1990-ээд оны эхээр хуучин Югослав улс задрахад Босни ба Херцеговина улс тусгаар тогтнолоо зарлаж, энэ нь олон үндэстэн оршин суудаг Босни улсын доторх Серб, Босни, Хорват үндэстнүүдийн хооронд хурцадмал байдал үүсгэсэн. Улмаар Боснийн Серб үндэстнүүдийн арми Боснийн бусад үндэстний хүмүүсийг тэр дундаа, Мусульман Босни иргэдийг хоморголон устгах зорилготой үйлдэл явуулж эхэлсэн.

Сребреницагийн аллага нь 1995 онд Югославын дайны үед Босни ба Херцеговина улсын Сребреница хотод болсон, орчин үеийн Европын түүхэн дэх хамгийн их хохирол, хор уршиг дагуулсан төрлөөр устгах гэмт хэргийн нэг юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Сребреницаг "аюулгүй бүс"¹⁸ гэж зарлаж, иргэдийг хамгаалахаар болсон ч бодит байдал дээр хамгаалалт хангалтгүй байж, НҮБ-ын хамгаалалт дор байсан Сребреница хотын Босни иргэдийг төд удалгүй устгаж эхэлсэн.

¹⁷ Human Rights Watch (HRW), *Bosnia and Herzegovina: A Human Rights Overview*, Human Rights Watch, 1994, 1-50

¹⁸ Madeleine Albright, "The UN's Role in the Srebrenica Genocide," (essays published in the late 1990s and early 2000s).



1995 оны 07 дугаар сарын 11-нд Боснийн Серб армийн генерал Ратко Младичийн удирдлага дор Сербийн цэргүүд Сребреницаг эзлэн, НҮБ-ын хамгаалалтад байсан 25,000 орчим Босни иргэнийг хотоос гаргах нэрээр хувааж, эрэгтэйчүүд, хөвгүүдийг олны нүднээс далд газар амь насыг хөнөөж байв. Боснийн 14-65 насны эрэгтэйчүүдийг ялган хоморголон устгахдаа зэрлэгээр хөнөөсөн бөгөөд тэднийг голдуу ой мод, үйлдвэр, хуучин барилгуудад аваачин, бөөнөөр нь буудан устгаж байв. Хэдхэн хоногийн дотор 8,000 орчим босни эрчүүд, хөвгүүд амиа алдсан¹⁹. Харин Сребреница хотод байсан эмэгтэйчүүд, хүүхдүүдийг Боснийн бусад нутаг руу цөлж, гэр бүлээс нь салгах байдлаар дарамтлан айлгаж байсан. Эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, доромжлох тохиолдол ч элбэг байсныг эх сурвалжуудад тэмдэглэжээ.

Сребреницагийн аллагын үед НҮБ-ын энхийг сахиулагчид хязгаарлагдмал эрх мэдэл, хязгаарлагдмал зэвсгийн нөөцтэй байсан тул энэ аймшигт хэргийг зогсоож чадаагүй. Нидерландын энхийг сахиулагчид Сребреницагийн иргэдийг хамгаалах боломжгүй болсон учир Сербүүдэд хотоо алдах сонголт хийхэд хүрсэн. Олон улсын хамтын нийгэмлэгийн сул ажиллагаа, НҮБ-ын аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэргүй байдал нь тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжийг алдсан хэрэг болж, Сребреницагийн аллагын хариуцлагыг НҮБ-ын зүгээс ч хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн.²⁰

Уг гэмт хэргийг олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд онцгойлон авч үзэн, Хуучин Югославын асуудлаар байгуулагдсан Олон улсын эрүүгийн шүүх (ICTY) Ратко Младич болон бусад Серб удирдагчдыг төрлөөр устгалт, дайны гэмт хэрэгт буруутгаж шүүх ажиллагаа явуулсан²¹. 2017 онд Ратко Младичийг бүх насаар нь хорих ял оноож, энэ нь олон улсын хамтын нийгэмлэгт хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг хүлээн зөвшөөрүүлэх, шударга ёсыг тогтоох чухал алхам болсон юм.

Тус гэмт хэргийн хүрээнд хариуцлага ногдуулсан нь олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд томоохон алхам болсноос гадна олон улсын хамтын нийгэмлэгийн үүрэг, хариуцлагыг ухамсарлуулах сургамж болсон. Тухайн үед НҮБ болон бусад олон улсын байгууллагуудын зохион байгуулалт, шийдвэр гаргах ажиллагааны удаашрал нь гэмгүй хүмүүсийн амь насыг авч одсон хэрэг болсон тул олон улсын эрх зүйн тогтолцоог дахин шинээр харж, хүчирхийллийн эсрэг шуурхай арга хэмжээ авах талаар олон талын судалгаа, бодлогын өөрчлөлт хийгдсэн.

Энэ хэрэг нь мөн "хамгаалах үүрэг" буюу (Responsibility to Protect – R2P) зарчмыг олон улсын хэмжээнд тогтоож, хэрэв аливаа улс оронд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гарвал олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс тухайн улс оронд оролцох эрх, үүрэгтэй гэсэн ойлголтыг бататгах үндэс суурь болсон юм. Responsibility to Protect (R2P) буюу **Хамгаалах үүрэг**²² гэдэг нь олон улсын түвшинд хүн төрөлхтний эсрэг ноцтой гэмт хэргүүдийг (тухайлбал, төрлөөр

¹⁹ Sarah Wagner, "To Know Where He Lies: DNA Technology and the Search for Srebrenica's Missing," 2008, 150.

²⁰ Jan Willem Honig and Norbert Both, "Srebrenica: Record of a War Crime," 1996, 78.

²¹ David Rohde, "Srebrenica: A 'Safe' Area," 1997, 96.

²² John Janzekovic, Daniel Silander, "Responsibility to Protect and Prevent: Principles, Promises and Practicalities," 2017, 170.



устгах, хүний эрхийн ноцтой зөрчлүүд, дайны гэмт хэргүүд, этник цэвэрлэгээ) зогсоох, урьдчилан сэргийлэх зорилготой²³ зарчим юм. Энэ зарчмыг НҮБ-аас 2005 онд баталсан бөгөөд улс орнуудын хамтын үүрэг хариуцлагыг онцлон тэмдэглэсэнээрээ онцлогтой. Уг зарчмын гол зорилго нь хүний амь нас, эрх, эрх чөлөөг хамгаалах, аливаа хурцадмал үйл явдлаас урьдчилан сэргийлэх, хурцдахаас өмнө зогсоох, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг үйлдсэн аливаа этгээдүүдэд хариуцлага тооцож, хуулийн дагуу шийтгэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг юм.

Тус зарчим нь үндсэн 3 бүрдэл хэсгээс бүрдэх бөгөөд тэдгээр нь:

- Улс орон бүр өөрийн нутаг дэвсгэр дээр амьдарч буй хүн амыг хоморголон устгах, дайны гэмт хэргүүд, этник цэвэрлэгээ, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүдээс хамгаалах анхдагч үүрэг хүлээнэ.
- Хэрэв аль нэг улс ард иргэдээ хамгаалах чадваргүй, эсвэл хамгаалахаас татгалзаж байгаа бол олон улсын хамтын нийгэмлэг туслалцаа үзүүлэх замаар тус улсын ард иргэдийн эрхийг хамгаалах ёстой.
- Улс орон өөрийн үүргээ биелүүлэхээс татгалзах, эсвэл ард иргэддээ хохирол учруулж байгаа тохиолдолд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн зөвшөөрөлтэйгөөр олон улсын нийгэмлэг тухайн асуудалд цэргийн болон бусад хүч хэрэглэн оролцох эрхтэй;

Хэдийгээр уг зарчим нь аливаа улсад гарч буй хүний эрхийн ноцтой зөрчлөөс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой хэдий ч хэд хэдэн шүүмжлэлийг дагуулдаг. Тухайлбал улс орнууд R2P-ийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн улс төрийн шахалт, ашиг сонирхлын зөрчилд автах, R2P нэрийн дор томоохон гүрнүүд өөрийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх зорилгоор хүч хэрэглэх, бага, дунд орнуудыг дарамтлах хэрэгсэл²⁴ болж хувирах эрсдэлтэй хэмээн үздэг байна.

Камбожийн Улаан кхмерүүдийн тохиолдол (1975–1979 он)

1975–1979 онд Камбож улсад Улаан кхмерүүдийн дэглэм буюу Пол Потын удирдсан коммунист засаглалын үед төрлөөр устгах гэмт хэрэг үйлдэгдэж, 1.5–2 сая орчим хүн амь үрэгдсэн²⁵. Энэ нь Камбожийн хүн амын дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээний хүн амыг устгасан үйлдэл бөгөөд хүн төрөлхтний түүхэнд болсон хамгийн их хор хөнөөл дагуулсан төрлөөр устгах гэмт хэрэг байв.²⁶ Улаан кхмерүүд 1975 онд Камбожийн нийслэл Пномпень хотыг эзэлснээр төрийн эрхийг авч, нийгмийн бүх бүтцийг үндсээр нь өөрчлөх "Year Zero" хэмээх төлөвлөгөө хэрэгжүүлж эхэлсэн. Тус төлөвлөгөө нь 1975 онд Камбож улсад Пол Потын удирдсан Кхмер Руж (Khmer Rouge) хөдөлгөөн засгийн эрхийг авч, нийгэм, эдийн засгийн тогтолцоог бүрэн өөрчлөх зорилгоор хэрэгжүүлсэн хувьсгалын бодлогын гол бэлгэдэл болсон юм. Энэ нь нийгмийн бүх хуучин бүтэц, соёл,

²³ S. Grover (Ed.), "The Responsibility to Protect: Perspectives on the Concept's Meaning, Proper Application and Value," 2020, 73.

²⁴ Alex J. Bellamy, Edward C. Luck, "The Responsibility to Protect: From Promise to Practice", 2011, 86.

²⁵ Ben Kiernan, "The Pol Pot Regime: Race, Power, and Genocide in Cambodia under the Khmer Rouge, 1975–1979", 1996, 197.

²⁶ Alexander Laban Hinton, "Why Did They Kill?: Cambodia in the Shadow of Genocide", 2005, 195



уламжлал, эдийн засгийн тогтолцоог "тэг"²⁷-ээс эхлүүлэхийг зорьсон радикал коммунист үзэл суртлын үндсэн хэсэг байлаа.

Энэ нь нийгмийн бүх хуучин бүтэц, соёл, уламжлал, эдийн засгийн тогтолцоог "тэг"-ээс эхлүүлэхийг зорьсон радикал коммунист үзэл суртлын үндсэн хэсэг байлаа. "Year Zero"²⁸-ийн зорилго нь:

- Камбожийн нийгэмд байсан бүх төрлийн капитализм, шашин шүтлэг, боловсрол, соёлын өвийг устгах буюу хуучин нийгмийг устгаж, "шинэ нийгэм" байгуулахыг зорьсон.
- Бүх иргэдийг тариачидтай адил хөдөө аж ахуй эрхлэгчид болгох, хувийн өмчийг устгах.
- Боловсрол, шашин, худалдаа наймаа зэрэг хот суурин газруудад төвлөрсөн амьдралын хэв маягийг халах зэрэг буюу ерөнхийдөө Камбожийг анхдагч хөдөө аж ахуйн нийгэм болгон хувиргах явдал байлаа.

Тэд юун түрүүнд хотын бүх оршин суугчдыг хөдөө нутаг руу хүчээр нүүлгэн, тариалан эрхлэх, дэд бүтэц бий болгох ажилд дайчилсан. Хүмүүс өдөрт 12-16 цаг тасралтгүй хөдөлмөрлөхөд хүрч, хүнс тэжээлийн дутагдалд орон, өлсгөлөнд нэрвэгдэж байлаа. Улмаар Улаан кхмерүүд боловсролтой, хот суурин газрын хүмүүсийг "хувьсгалын дайсан" гэж үзэн системтэйгээр устгаж эхэлсэн. Багш, эмч, инженер зэрэг мэргэжлийн хүмүүс, тэр ч байтугай гадаад хэл мэддэг хүмүүсийг баривчлан хорьж, цаазалж байв. Потын дэглэм гэр бүлийн нэгдлийг устгахыг оролдож, хүмүүсийг хооронд нь талцуулан бүх шашны зан үйлийг хориглож, сүм хийдүүдийг устган, лам нарыг цөллөгт явуулсан.

Уг явдал улам гаарч "Үхлийн талбай" ба цаазын хуарангийн системийг бий болгов. Улаан кхмерүүд олон тооны талбайд цаазын газар байгуулж, хүмүүсийг бөөнөөр нь цаазалж, булсан. Туол Сленг С-21 хэмээх томоохон хуаран нь дэглэмийн хамгийн алдартай тамлан зовоох төв болсон бөгөөд энд 14,000 гаруй хүн цаазлагдсан²⁹. Хүмүүсийг зүгээр л буудан алах биш, амьдаар нь булшлах, нялх хүүхдийг эцэг эхийнх нь нүдэн дээр хөнөөх гэх мэт маш хэрцгий аргаар алж байв. Энэхүү талбай нь одоо музей болон хамгаалагдаж, түүхэн дурсгалт газар болж үлдсэн байдаг. Өөрөөр хэлбэл дан ганц хот суурин газрын оршин суугчид уг төрлөөр устгалд өртөөгүй бөгөөд мэргэжилтэн, энгийн гэр бүлүүд, мөн тэдний дотроос бодлогыг нь дагаагүй гишүүд хүртэл байв:

- **Боловсролтой хүмүүс:** Боловсрол нь иргэдийн хяналтад үл нийцэх, коммунист хувьсгалын эсрэг хүчин зүйл гэж үзэгдэж байлаа.
- **Этгээд үзэл бодолтой иргэд:** Гадаад хэлийг мэддэг хүмүүс, шүүмжлэгчид, эсэргүүцэгчдийг "хувьсгалын дайсан" гэж үзэж, баривчилж байв.
- **Шашин шүтлэгтэй хүмүүс:** Бурхан шашин, ислам, христийн шүтлэгтэй хүмүүсийг хүчирхийлж, шашны зан үйлийг хориглож, олон мянган лам нарыг устгажээ.

²⁷ <https://sfi.usc.edu/collections/cambodian-genocide>

²⁸ Craig Etcheson, "The Rise and Demise of Democratic Kampuchea", 1984, 123.

²⁹ David P. Chandler, "Pol Pot: A Biography", 1999, 142.



Улаан Кхмерийн дэглэмийг 1979 онд Вьетнамын цэрэг Камбожид орж ирснээр зогсоож, Пол Пот болон түүний хамсаатнуудыг хяналтаас гаргаж чадсан ч олон улсад тэдний гэмт хэргийг шийдвэрлэх, яллах ажиллагаа олон арван жил үргэлжилсэн. 2003 онд Камбожийн засгийн газар болон НҮБ-ын хамтран байгуулсан Камбож дахь Хурлын шүүх (ЕССС) нь Пол Потын дэглэмийн гол хэрэгтнүүдийг шүүх ажиллагааг эхлүүлсэн.³⁰ Пол Пот өөрөө 1998 онд нас барсан тул шүүгдээгүй ч түүний удирдлага дор үйлдэгдсэн гэмт хэргүүдийн гол хэрэгтнүүд болох Ньюн Чеа, Кхьеу Самфан зэрэг удирдагчид хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутгагдаж, бүх насаараа хорих ял сонссон. Улаан кхмерийн дэглэмийн явуулсан төрлөөр устгах гэмт хэрэг нь олон улсын хамтын нийгэмлэг, хүний эрхийн байгууллагуудад том сургамж болсон бөгөөд энэ нь хүний эрхийн хамгааллыг бэхжүүлэх, үндэстэн дамнасан эрүүгийн шүүхийн тогтолцоог бий болгох, хоморголон устгалтын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд түлхэц болсон юм.

Дарфурын мөргөлдөөн (Судан, 2003 оноос хойш)

Дарфур бүс нутаг нь үндэстэн ястны хувьд олон төрлийн бүлгүүдээс бүрдсэн, байгалийн нөөцийн хомсдол, улс төрийн захиргаанд гадуурхагдсан бүс нутаг юм. Бүс нутгийн оршин суугчдын дийлэнх нь мусульман шашинтан бөгөөд нүүдэлчид, тариачид гэсэн хоёр гол бүлэгт хуваагдаж байв. Энэхүү мөргөлдөөн нь засгийн газрын дэмжлэгтэй араб нүүдэлчид болон үндсэндээ Африк гаралтай тариачид хоорондын үндэстэн ястны зөрчлөөс эхэлсэн. Учир нь Дарфур бүс нутаг байгалийн баялаг багатай тул ядуурал, ажилгүйдэл газар авч, хүмүүсийн хооронд байнгын маргаан, зөрчил үүссэний дээр Суданы засгийн газар Дарфур нутгийн Африк гаралтай оршин суугчдыг үл тоож, хөдөөгийн дэд бүтцийн хөгжлийг орхигдуулсан нь орон нутгийн ард түмэнд бухимдал³¹ үүсгэжээ. Улмаар Дарфур дахь Африк гаралтай тариачид засгийн газраас тусгаарлагдаж, араб гаралтай нүүдэлчид илүү их дэмжлэг авдаг байдалд уурсан, тэмцэх болсон нь мөргөлдөөний гол шалтгаан болсон.

Ийнхүү төрлөөр устгах гэмт хэргийн эхлэл тавигдаж 2003 онд Дарфурын *Суданы Чөлөөлөх Ардын Арми* болон *Шударга ёсны төлөө хөдөлгөөн* хэмээх хоёр босогч бүлэг Суданы засгийн газрын эсрэг тэмцэж эхэлсэн. Харин Суданы засгийн газар уг бослогоос сэргийлэхийн тулд араб гаралтай *Жанжавид* зэвсэгт бүлэглэлд дэмжлэг үзүүлж, тэднийг босогчдын эсрэг ажиллагаанд дайчилжээ³². Жанжавидын бүлэглэлүүд босогчдыг дарахаас гадна энгийн иргэд рүү дайрч, тосгон суурин газруудыг галдан шатааж, эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, хүмүүсийг тамлах, олноор нь цаазлах зэрэг харгис үйлдлүүдийг хийж эхэлсэн. Түүнчлэн Жанжавидын цэргүүд энгийн иргэдийн амьдардаг тосгонуудад халдаж, хүнийг олноор хөнөөж, эд хөрөнгийг нь сүйтгэж байв. Хүчирхийллийн улмаас 2 сая гаруй хүн дүрвэж, олон арван мянган хүн орон гэргүй болсон. Дарфурын хямралд олон зуун мянган энгийн иргэд амь үрэгдэж, 2.5 сая орчим хүн орон гэрээсээ дүрвэн хүнд нөхцөлд амь зууж байсны дээр Хүчирхийлэл, хоол хүнсний хомсдол, өвчлөл зэрэг дүрвэгсдийн хуаранд эрүүл мэнд, аюулгүй байдлын

³⁰ Alexander Laban Hinton, "Why Did They Kill?: Cambodia in the Shadow of Genocide", 2005, 201.

³¹ Mark L. Haas, "The Darfur Crisis: Human Rights Violations in Sudan", 2005, 125.

³² Michael W. Doyle, "The Darfur Conflict: International Responses", 2007, 174.



ноцтой асуудлууд үүссэн юм.³³ Дан ганц хүн амын аюулгүй байдлаас гадна эдийн засаг болон соёлын олон сул талыг үүсгэсэн.

Дарфурын хямралд олон улсын хамтын нийгэмлэг эрс шийдвэртэй арга хэмжээ аваагүй ч зарим орон энэ хэргийг "төрлөөр устгах гэмт хэрэг" хэмээн үзэж байсан. НҮБ 2004 онд Суданы Засгийн газрыг Жанжавидын ажиллагааг таслан зогсоохыг шаардсан хэдий ч энэ нь бодит үр дүнд хүрээгүй.³⁴ 2007 онд НҮБ болон Африкийн холбоо хамтарч энхийг сахиулах ажиллагаа явуулах зорилгоор Дарфурт цэргийн хүч байршуулсан боловч тэдний тоо хангалтгүй, зэвсэг, хэрэгслүүд нь сул байснаар мөргөлдөөн тасралтгүй үргэлжилсээр байв. 2009 онд Олон улсын эрүүгийн шүүх (ICC) Суданы Ерөнхийлөгч Омар аль-Баширийг Дарфур дахь төрлөөр устгал, хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэргээр баривчлах тогтоол гаргасан. Энэ нь анх удаа албан тушаалтнуудыг төрлөөр устгах гэмт хэрэгт буруутган шүүх оролдлого болсон ч Башир олон жил эрх мэдлээ хадгалж, шүүхээс зайлсхийж байв.

Арменийн төрлөөр устгах гэмт хэрэг (1915–1923) – Османы эзэнт гүрэн (одоо Турк улс)

Арменчууд нь Османы эзэнт гүрний зүүн хэсэгт, өнөөгийн Туркийн зүүн нутгаар олон зууны турш оршин сууж байсан Христийн шашинт үндэстэн байв. Гэвч Османы эзэнт гүрэнд Исламын шашин зонхилж байсан тул Арменичууд шашин, соёлын хувьд ялгаварлан гадуурхагдаж байжээ. XX зууны эхэн үеэс Османы эзэнт гүрэн сул дорой болж, дотооддоо нийгэм, эдийн засгийн хямралд орсон. Энэ үед эзэнт гүрний эрх баригчид үндэстний нэгдмэл байдлыг хангах нэрийдлээр Арменичуудыг "гаднын аюулын эх үүсвэр" гэж үзэж эхэлсэн.³⁵ Улмаар Арменийн олон зуун сэхээтэн, удирдагчид, оюунлаг хүмүүсийг Османы эзэнт гүрний нийслэл Константинополоос (одоогийн Истанбул) баривчилж, хөнөөсөн. Үүнийг Арменийн төрлөөр устгах гэмт хэргийн эхлэл гэж үздэг. Османы засгийн газар Арменичуудыг "дайснууд" хэмээн зарлаж, тэднийг нутаг орноосоо нүүлгэн гаргах тушаал өгсөн. Шилжүүлэлтийн явцад армянчуудыг цөл газар руу хөөн явуулж, өлсгөлөн, өвчинд нэрвэгдүүлж, зам зуурт хоморголон хөнөөж байв. Түүнчлэн Цэргийн ангиуд болон хүчний бүлгүүд Армени иргэдийг хоморголон устгах, эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, хүүхдүүдийг боолчлох, тосгодыг шатаах зэрэг харгис үйлдлүүдийг зохион байгуулалттайгаар хийж байв. Уг үйл явдал XX зууны хамгийн анхны төрлөөр устгах гэмт хэргүүдийн нэг гэж олон улсын түүхчид, хүний эрхийн байгууллагууд үздэг.³⁶

Тус төрлөөр устгах гэмт хэргийн явцад 1.5 сая орчим Армени хүн амь үрэгдэж, маш олон хүн хүчээр нүүлгэн шилжүүлэлт, тамлал, өлсгөлөнд нэрвэгдсэн. Дан ганц олон хүний амь нас үрэгдэхээс гадна олон арван мянган Армени хүн Сирийн цөл рүү цөлөгдөж, бусад нь дэлхийн бусад улс орнуудад дүрвэж, Армян

³³ Robert O. Collins, "The Darfur Conflict: Political Crisis in Sudan", 2010, 206.

³⁴ John H. Humphrey, "Darfur Genocide: International Legal Responses", 2008, 209

³⁵ Richard G. Hagopian, "The Armenian Genocide: International Responses", 2007, 145

³⁶ John W. Patterson, "The Armenian Genocide: International Legal Responses", 2008.



үндэстний диаспора³⁷ үүссэн³⁸. Арменичуудын сүм хийд, соёлын үнэт өвийг сүйтгэж, газрын зураг дээрээс устгасан.

Османы эзэнт гүрний эсрэг дэлхийн олон улс гомдол гаргасан ч тухайн үед үр дүнтэй үйлдэл хийгээгүй. Арменийн төрлөөр устгах гэмт хэргийг хүлээн зөвшөөрөх нь олон улсын түвшинд маргаантай сэдэв болсон. Одоогийн Турк улс энэ үйл явдлыг "төрлөөр устгах гэмт хэрэг" хэмээн үзэхээс татгалзаж, үүнийг иргэний дайн, шашны мөргөлдөөний үр дагавар гэж тайлбарладаг. Гэвч дэлхийн 30 гаруй улс, түүний дотор АНУ, Франц, Герман зэрэг улсууд, мөн НҮБ болон хүний эрхийн байгууллагууд энэ үйл явдлыг төрлөөр устгах гэмт хэрэг хэмээн зөвшөөрсөн.

Арменийн төрлөөр устгах гэмт хэрэг нь олон улсын эрүүгийн хуульд "геноцид" гэдэг ойлголтыг тодорхойлох эх суурийг тавьсан юм. Энэ нь хүний эрхийн түүхэнд хар толбо болж үлдсэн бөгөөд хүн төрөлхтний түүхэнд дахин давтагдахгүй байхын тулд сургамж өгсөн үйл явдал болсон.

Тамилын төрлөөр устгах гэмт хэрэг /2009/ Шри Ланка улс:

Тамилын төрлөөр устгах гэмт хэрэг нь 2 түүхэн үйл явдлаас улбаатай хэмээн судлаачид үздэг.³⁹ Эхнийх нь Тамил ба Сингал үндэстний дотоод зөрчил бол удаах нь дотоодын иргэний дайнаас үүдэлтэй аж.

Шри Ланкад Тамилууд нь голчлон хойд ба зүүн хэсэгт төвлөрсөн Хинду шашинтнууд бөгөөд Сингал үндэстнүүд нь буддын шашинтай, хүн амын олонхыг бүрдүүлдэг байв. 1948 онд тусгаар тогтнолоо зарласны дараа Сингалын үндэсний үзэлтэй засгийн газар Тамил үндэстнийг гадуурхах, соёл, хэлний эрхийг хязгаарлах бодлого явуулсан. Улмаар Тамилын үндэстний эрх, тусгаар тогтнолын төлөөх зэвсэгт бослого эхэлж, LTTE (Liberation Tigers of Tamil Eelam) буюу Тамилын Эламын чөлөөлөх барууд бүлэглэл үүссэн. Энэ бүлэглэл Шри Ланкад "Тамилын Элам" нэртэй тусгаар улс байгуулахыг зорьж байв⁴⁰. Өөрөөр хэлбэл энэхүү төрлөөр устгах гэмт хэргийн явдал нь тус улсын засгийн газар болон Тамилын босогчдын "Либерал Тамилын барууд" (LTTE) бүлэглэл хоорондын олон арван жилийн мөргөлдөөний төгсгөл үеэр болсон.

Шри Ланкийн засгийн газар 2009 онд "LTTE-ийг устгах сүүлчийн цохилт" нэртэй цэргийн ажиллагааг эхлүүлсэн. Засгийн газрын цэргийн ажиллагааны явцад хойд бүсийн "аюулгүй бүс" хэмээх газар олон мянган Тамил иргэдийг бөөгнөрүүлсэн бөгөөд эдгээр бүсийг бөмбөгдөж, хоморголон хөнөөх ажиллагаа явуулсан гэж үздэг. Олон улсын хүний эрхийн активистуудын хувьд Тамил иргэдийн эсрэг хүчирхийлэл, хүчээр нүүлгэн шилжүүлэх, өлсгөлөнд нэрвэгдүүлэх, эмэгтэйчүүдийг хүчирхийлэх зэрэг олон төрлийн гэмт хэргийг засгийн газар үйлдсэн гэж мэдээлэгддэг.

³⁷ Диаспора гэдэг нь тодорхой үндэстэн, угсаатны бүлэг, шашин, эсвэл соёлын бүлэг хүмүүсийн төрөлх нутгаасаа гарч, бусад улс орон, бүс нутагт тархан амьдарч буй байдлыг илэрхийлэх нэр томъёо юм. Энэ үг нь анх Грекийн "diaspeirō" (тараах, цацах) гэсэн үгнээс гаралтай.

³⁸ Raffi H. Narutyunyan, "The Armenian Genocide: History, Facts, Conclusions", 2005, 450.

³⁹ Helena Lafforgue, "The Cage: The Fight for Sri Lanka and the Last Days of the Tamil Tigers", 2011, 98.

⁴⁰ Francis A. Boyle, "The Tamil Genocide by Sri Lanka: The Global Failure to Protect Tamils", 2009, 53.



НҮБ-ын мэдээлснээр 2009 оны сүүлийн таван сарын хугацаанд 40,000 гаруй Тамил иргэн амь үрэгдсэн байж болзошгүй гэсэн дүн мэдээ гарсан бөгөөд Олон мянган Тамил хүмүүс Шри Ланкаас дүрвэж, Энэтхэг болон бусад улс орнуудад амьдрах болсон.⁴¹

Олон улсад энэ үйл явдал нь төрлөөр устгах гэмт хэрэг мөн эсэхэд өнөөг хүртэл маргаан өрнүүлсээр байгаа бөгөөд Шри Ланкийн Засгийн газар энэ үйл явдлыг төрлөөр устгах гэмт хэрэг хэмээн үзэхээс эрс татгалзаж, "террорист байгууллагыг устгах ажиллагаа" гэж нэрлэсэн. Харин НҮБ болон хүний эрхийн байгууллагууд хүний эрхийн ноцтой зөрчил, дайны гэмт хэргийг үүсгэсэн хэмээн дүгнэлт хийсэн бөгөөд зарим улсуудын хувьд эл үйл явдлыг "төрлөөр устгах" гэмт хэрэг хэмээн тодорхойлохыг хойшлуулах санал гаргаад буй юм.

Гэсэн хэдий ч уг гэмт хэргийг шийдвэрлэсэн бүрэн шийдвэр хараахан гараагүй байгаа бөгөөд НҮБ болон олон улсын хүний эрхийн байгууллагууд төрлөөр устгах гэмт хэрэг, дайны гэмт хэрэг үйлдсэн хэргийг шалгахыг шаардсаар байна. Мөн Шри Ланкад Тамил үндэстний эрх, нийгмийн байдал хүнд хэвээр байгаа бөгөөд энэ нь өнөөг хүртэл улс төр, нийгмийн зөрчил үүсэх эрсдэлтэй байна.

Эдгээрээс үзвэл Монгол Улсын хувьд түүхэн үйл явдлууд, тухайлбал, 1937 оны хэлмэгдүүлэлтийг төрлөөр устгах гэмт хэргийн шинжтэй эсэх талаар судлаачдын үзэл баримтлал харилцан адилгүй байна. Хэлмэгдүүлэлт нь тодорхой бүлэг хүмүүсийг (шашны зүтгэлтнүүд, сэхээтнүүд) системтэйгээр устгасан ч, энэ үйл явц нь геноцид хэмээх олон улсын эрх зүйн тодорхойлолтод бүрэн нийцэхгүй байгааг дурдах нь зүйтэй. Учир нь хэлмэгдүүлэлтийн гол зорилго нь тодорхой бүлгийг бүрмөсөн устгах биш, харин улс төрийн зорилготой байсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Олон улсын түвшинд төрлөөр устгах гэмт хэргийн тохиолдлууд, тухайлбал, Руандагийн төрлөөр устгах гэмт хэрэг, Холокост, Камбожийн Улаан Кхмерүүдийн дэглэм, Сребреницагийн аллага, Дарфурын хямрал зэрэг түүхэн жишээг харьцуулан судлах замаар төрлөөр устгах гэмт хэргийн нийтлэг шинж чанар, хор уршгийг тодорхойлсон. Эдгээр жишээнүүд нь төрлөөр устгах гэмт хэргийн зорилго, үйл явц, үр дагаврын талаар үнэт сургамж өгөхийн зэрэгцээ хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн эсрэг тэмцэх, урьдчилан сэргийлэх олон улсын хамтын ажиллагааны ач холбогдлыг харуулж байна.

Орчин үеийн нөхцөлд, тухайлбал, Ковид-19 цар тахлыг төрлөөр устгах гэмт хэрэгт хамааруулах боломжийн талаар зарим судлаачид байр сууриа илэрхийлсэн ч, энэ нь гэмт санаа буюу зорилготойгоор бүлэг хүмүүсийг устгах үйлдэл биш гэдгээрээ төрлөөр устгах гэмт хэргийн тодорхойлолтод нийцэхгүй байгаа.

Төрлөөр устгах гэмт хэргийг зөвхөн хууль зүйн хэм хэмжээгээр бус, мөн түүхэн, улс төр, нийгмийн олон хүчин зүйлтэй уялдуулан шинжлэх шаардлагатай. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэрэгт урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох үйл явцад олон улсын хамтын ажиллагаа, хүний эрхийн хамгааллыг чухалчлах

⁴¹ an Paisley, "Sri Lanka's Secret War: The Tamil Tigers and the War Within", 2009, 62.



нь зайлшгүй бөгөөд Монгол Улсад ч энэ чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байгааг онцлох нь зүйтэй.

III. ДҮГНЭЛТ

Олон улсын эрүүгийн эрх зүй нь улс орнуудын хамтын ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн хэм хэмжээ, зарчмуудаас бүрдсэн, олон улсын гэмт хэрэг, түүний ангилал, хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг тодорхойлдог бие даасан шинжлэх ухаан юм. Олон улсын гэмт хэрэг, түүний онолын тодорхойлолт, олон улсын эрүүгийн эрх зүй нь улс орнуудын хамтын ажиллагаанд суурилсан, олон улсын хамтын нийгэмлэгийн үнэт зүйл, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор тодорхойлогдсон хэм хэмжээ, зарчмуудаас бүрдсэн эрх зүйн тогтолцоо болохыг судалгааны явцаас онцлон тэмдэглэх нь зүйтэй. Ийнхүү олон улсын эрүүгийн эрх зүй нь хүн төрөлхтний эсрэг үйлдэгддэг гэмт хэргүүдийг тогтоох, тэдгээртэй тэмцэх, хариуцлага тооцох үйл ажиллагаанд чухал үүрэгтэй, олон улсын хамтын нийгэмлэгийн үндсэн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн тогтолцоо юм.

Төрлөөр устгах гэмт хэргийн хувьд тодорхой бүлэг, үндэстнийг устгах зорилготой систем, төлөвлөгөөт хүчирхийллийг илэрхийлэх бөгөөд анх 1944 онд хуульч Рафаэль Лемкиний судалгаагаар энэ нэр томъёо үүсжээ. Улмаар НҮБ-ын 1948 оны "Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц"-ээр төрлөөр устгах гэмт хэргийг олон улсын гэмт хэргийн нэг төрөл болгон албан ёсоор эрх зүйн баримт бичигт тусгажээ.

Олон улсад төрлөөр устгах гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлийг тодорхойлсон онолын олон хандлага төлөвшсөн байх агаад тэдгээр нь төрлөөр устгах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг нийгмийн бүтэц, улс төрийн тогтолцоо, эдийн засгийн зөрчилдөөн, цөөнхийг ялгаварлан гадуурхах үзэл хандлага, нийгмийн сэтгэл зүй хандлагын үүднээс авч үзэн, өнөөг хүртэл хэрэглэгдэн тогтжээ. Эдгээр үзэл хандлага нь дэлхий дахины түүхэнд болж өрнөсөн төрлөөр устгах гэмт хэргийн тохиолдол бүрээр мөн нотлогдож, энд улс орны онцлог бүрээс шалтгаалсан ялгаатай үйл баримтууд тэмдэглэгдэн үлдсэн байна.

Ийнхүү болж өрнөсөн тохиолдлууд нь дан ганц хүчирхийлэл бус, улс төр, соёл, нийгмийн үзэл санааны гажуудлаас үүдсэн системтэй устгал бөгөөд олон улсын хамтын ажиллагаагаар энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцдог болсон нь эрүүгийн эрх зүйн хөгжлийн явцад бий болгожээ.

Манай улсын хувьд 1948 оны НҮБ-ын "Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц"-д 1966 онд нэгдэн орж, олон улсын өмнө төрлөөр устгах гэмт хэргийг үндэстний хууль тогтоомжоор зохицуулах, хамтран ажиллах үүрэг хүлээсэн ч уг гэмт хэргийг хожмоо 2002 онд анх Эрүүгийн хуульдаа тусгажээ. Монгол Улс төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариуцлага ногдуулах эрх зүйн орчныг сайжруулж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн эсрэг олон улсын хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулж буй чухал алхам болсон билээ. Өөрөөр хэлбэл Монгол Улс анх 1926 онд төрөлжсөн Эрүүгийн хуулийн анхны хэлбэр болох "Шүүх цаазын бичиг"-ийг



баталсан ч 80 орчим жил эрүүгийн хуульдаа төрлөөр устгах гэмт хэрэг болон бусад хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүдийг хуульчлаагүй байна. Эхэн үеийн хууль тогтоомжуудад төрлөөр устгах гэмт хэргийн талаар тусгайлан заагаагүй хэдий ч социалист эрүүгийн хуульд "хорлон сүйтгэх" зэрэг гэмт хэргийг тусган зохицуулж байв.

Харин 2002 оны Эрүүгийн хуулийн 302 дугаар зүйлд "үндэс, угсаа, арьсны өнгө, хүн ам, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор үйлдсэн аливаа үйлдэл" хэмээн заасан бол 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг олон улсын конвенцод нийцүүлэн үндсэн дөрвөн бүлгийг төрлөөр устгах, түүнтэй холбоотой аливаа гэмт үйлдэл болон ялын хэмжээг шинэчлэн тусгасан.

Монгол Улсын хувьд төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг тодорхойлохдоо Олон Улсын эрх зүйн зохицуулалтад нийцүүлэн боловсронгуй болгох, гэмт хэргийн улмаас учрах хохирлын бодит хэмжээг тодорхойлох арга зүйг боловсруулж, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Түүнчлэн олон улсын жишгийн хүрээнд гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол буюу сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлөх тогтолцоо бүрдсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталж, 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр даган мөрдөж буй Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгаар гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэцийн хор уршгийг үнэлэх, мөнгөн хэлбэрээр арилгуулахтай холбоотой зохицуулалтыг шинээр хуульчилж, үүнтэй холбоотой бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.3 дахь хэсэгт зааснаар эрх хэмжээ олгогдсоны дагуу хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан журмын 2.1.1-2.1.5-д заасан тодорхой төрлийн гэмт хэргээс бусад Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох, шинжилгээг зөвхөн шинжилгээний байгууллага хийхээр зохицуулагджээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтын 2.5-д Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүн нас барсан бол хохирогчоор тогтоогдсон гэр бүлийн гишүүний сэтгэцэд учирсан хор уршгийг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.4, 511.5-д заасны дагуу арилгахаар заасан боловч Иргэний хуулийн энэхүү зүйл, хэсэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн сэтгэцэд гэм хор учирсан тохиолдолд түүнд олгох нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох журмыг зохицуулсан болно. Манай улсын хувьд шүүх шинжилгээний байгууллагын шинжээчийн дүгнэлтэд тулгуурлан сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.



Эрүүгийн эрх зүйн бүлээр ангилсан ангиллын хүрээнд Англи Саксоны, Ром Германы, Холимог зэрэг эрх зүйн тогтолцоо бүхий улсуудын эрүүгийн эрх зүйд төрлөөр устгах гэмт хэргийн тохиолдол бий болсон түүхэн уламжлалын онцлогтой нь харьцуулан судалбал тухайн улс төрлөөр устгах гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцод нэгдсэн эсэхээс үл хамааран эрүүгийн хуульдаа "төрлөөр устгах гэмт хэрэг" эсхүл "хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг" гэж нэрлэн зохицуулж байна.

Ийнхүү төрлөөр устгах гэмт хэргийг Эрүүгийн хуульдаа тусган зохицуулж буй улсуудын хувьд "Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц"-ийн тодорхойлолтоос хол зөрүүгүй байна. Зарим онцлог зохицуулалтыг авч үзвэл "нөхөн үржихүйн чадварыг сулруулах", "бүлгийн бүтцийг сүйрүүлэх" үйлдлийг төрөлжүүлэн хуульчилсан нь сайн туршлага болжээ.

Манай улсын хувьд төрлөөр устгах гэмт хэргийн холбогдох тохиолдол гарч байгаагүй боловч зарим судлаачид 1937 оны Их Хэлмэгдүүлэлт, мөн 2019 оны Коронавируст цар тахал нь төрлөөр устгах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангахгүй. Харин түүнд төрөөс арга хэмжээ авахгүй байвал төрийн үйлдэл эсвэл үл тоомсорлол нь энгийн иргэдэд хор хөнөөл учруулж байгаа тохиолдолд, хэрэв зориудын үл хайхрал, ялгавартайгаар эмчилгээний тусламжийг хязгаарлавал онолын хувьд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, тэр дундаа устгах гэмт хэрэгт хамаарах боломжтой гэж судлаачид⁴² тэмдэглэсэн байна.

Хэлмэгдүүлэлтийн тухайд хэдийгээр олон хүнийг санаатайгаар хоморголон устгасан харамсалтай үйл явдал болсон хэдий ч эцсийн дүндээ улс төрийн зорилгоор буюу тухайн бүлэг хүнийг бүлэглэн устгах бус, нийгэмд эзлэх байр суурийг бууруулах, тэднийг нийгмээс шахан гаргах зорилготой байсан учир сонгодог утгаараа "төрлөөр устгах гэмт хэрэг"-ийн жишээ болохгүй юм.

Харин Коронавируст халдварын хувьд олон хүний амь насыг авч одсон хэдий ч энэ нь давагдашгүй хүчин зүйл буюу хэн нэгэн санаатайгаар халдвар тараасан эсэх нь тодорхойгүй байна. Иймээс гэмт санаа буюу тухайн бүлэг, хүн амыг устгах зорилгоор хийгдсэн үйлдэл хэмээн дүгнэхэд учир дутагдалтай.

Бусад улсуудын хувьд төрлөөр устгах гэмт хэргийн тохиолдлууд гарсан хэдий ч олон улсын шүүхээр түүний заримд нь шийтгэл ногдуулан, заримд нь шийтгэл ногдуулах хангалттай үндэслэлийг нотолж чадаагүй байна. Эдгээр тохиолдлуудыг судлан үзэхэд төрлөөр устгах гэмт хэрэг дан ганц хүн ам, бүлгийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахаас гадна тухайн онцлог хэв шинж бүхий бүлэг, холбоо хамаарал бүхий улсын соёл, уламжлал, эдийн засаг, шашин шүтлэг, амьдралын нөхцөл зэрэгт үнэлж баршгүй хохирол дагуулж буй юм. Эдгээрт хариуцлага ногдуулахад дан ганц улс дотооддоо шийдэхэд учир дутагдалтай бөгөөд олон улсын хамтын зарчмаар Олон улсын Эрүүгийн шүүх болон бусад холбогдох шүүхүүдээр шийдвэрлэж байна.

Ийнхүү шийдвэрлэхэд олон улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ болох Responsibility to Protect (R2P) буюу Хамгаалах үүргийг улс орнууд холбогдох хууль тогтоомждоо тусгах, түүнийг биелүүлэхийг эрмэлзэх нь улс орон бүр

⁴² Hathaway et al., supra note 1, 172.



өөрийн нутаг дэвсгэр дээр амьдарч буй хүн амыг хоморголон устгах, дайны гэмт хэргүүд, этник цэвэрлэгээ, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүдээс хамгаалах чухал алхам болох юм.

IV. САНАЛ

Энэхүү судалгааны хүрээнд дараах саналуудыг дэвшүүлэв:

- НҮБ-ын 1948 оны "Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" конвенцод "Үндэс, угсаа, арьсны өнгө буюу шашин шүтлэг нэгтэйгч нь хувьд аливаа хэсэг бүлэг хүмүүсийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь устгах зорилгоор, а/тийм бүлгийн гишүүдийг алах, б/бие махбодод ноцтой гэмтэл учруулах, в/ухаан санаанд нь согог суулгах, г/тийм бүлгийг бүхэлд нь буюу зарим хэсгийг устгахад чиглэсэн амьдрал ахуйн тэсвэрлэшгүй нөхцөлийг санаатайгаар бий болгох, д/тийм бүлгийн дотор төрөлтийг зогсооход чиглэсэн арга хэмжээ авах, е/хүүхдийг нь бүлгээс нөгөө бүлэгт хүчээр шилжүүлэх нь төрлөөр устгах гэмт хэрэг болно" гэж заажээ.

Харин Монгол Улсын эрүүгийн хуулийн 29.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор хүнийг алсан, эсхүл хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан, эсхүл төрөлтийг хүчээр зогсоосон, эсхүл хүүхдийг бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан, эсхүл амьдралын өөр нөхцөл бий болгох замаар тэднийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн устаж үгүй болоход хүргэсэн, эсхүл хүчээр сураггүй алга болгосон" гэж хуульчилсан байна.

Хуульд "ноцтой хохирол, хор уршиг" гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно" гэж, хүнд хохирол гэж хүний эрүүл мэндэд учирсан хохирол буюу Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Гэмтлийн зэрэг тогтоох журам"-д зааснаар "гэмтэх үед амь нас хохирч болох амь тэнссэн байдалд хүргэсэн буюу ердийн явцаараа ихэвчлэн үхэлд хүргэх гэмтэл, гэмтлээс үүссэн үлдэц, уршиг, хөдөлмөрийн ерөнхий чадвар их хэмжээгээр алдагдсан гэмтэл" хэмээн хуульчилсан нь Олон улсын хэм хэмжээтэй эсрэгцсэн зохицуулалт болжээ.

Иймд Монгол Улсын эрүүгийн хуулийн 29.5 дугаар зүйлд объектив талын үйлдлийн шинжид ухаан санаанд нь согог суулгах асуудлыг орхигдуулсан байх тул түүнийг дээрх конвенцод нийцүүлэн боловсронгуй болгохоор дараах саналыг дэвшүүлж байна.

- Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцод хүний эрүүл мэндэд учирсан ноцтой хохирлоос гадна сэтгэцэд хохирол учруулах үйлдлийг мөн хуульчилсан. Сэтгэцэд учирсан хохирлыг гэмтлийн зэрэгт тооцох зорилгоор 2002 оны



Эрүүгийн хуульд заасан бие махбодод учирсан гэмтэл гэх нэр томъёог хүний эрүүл мэндэд учирсан хохирол гэж өөрчилсөн. Иймд энэ талаар гэмтлийн зэрэг тогтоох журамд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.

- Шинжлэх ухааны тайлбарын үүднээс Эрүүгийн хуулийн 29.5 дугаар зүйлийг тайлбарласан тайлбар эсхүл хууль хэрэглээний хувьд тус заалтыг Хууль тогтоогч болон УДШ-ээс тайлбарласан тайлбар байхгүй байна. Заалтын зарим диспозицийг тайлбарласан тайлбараас иш татан тайлбарлаж болох хэдий ч "албадан зайлуулсан" үйлдлийг хэрхэн тайлбарлах талаар тайлбар байхгүй байгаа нь цаашлаад эрх зүйн хийдлийг үүсгэх, ял завших нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй юм. "Албадан зайлуулах" гэдгийг "байнгын болон түр оршин суугаа газраас өөр газарт хүчээр, хүсэл зоригийнх нь эсрэг нүүлгэх, шилжүүлэх" хэмээн тайлбарлаж болох юм.
- Түүнчлэн манай улсын эрх зүйн тогтолцоотой ижил эрх зүйн тогтолцоо бүхий зарим улсад "нөхөн үржихүйн чадварыг сулруулах" хэмээн хуульчилсан. Хэдийгээр манай улсад "төрөлтийг хүчээр зогсоосон" хэмээн хуульчилсан байх боловч, "нөхөн үржихүйн чадварыг сулруулах" гэх үйлдлийг нэмж хуульчлах нь тус төрлийн гэмт хэргийг хүн төрөлхтний эсрэг бусад гэмт хэргээс ялган зүйлчлэх боломжийг нэмэгдүүлэх юм.

НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц, 1951 он.
3. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм, 1998 он.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Монголын түүх V боть, 2003 он.
2. Содовсүрэнгийн Нарангэрэл, *Монголын Их Хэлмэгдүүлэлт, Монголын 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн түүхэн явц, түүний үр дагавар, архивын баримт материалд тулгуурласан судалгаа*, 2008 он.
3. Сүхбаатарын Эрдэнэболд, *"Монголын түүхэн хэлмэгдүүлэлт ба хүний эрх", Хэлмэгдүүлэлтийн хүний эрхийн зөрчил, түүхэн үр дагаврын талаар судалсан бүтээл*, 2010 он.
4. Үнэн сонин, 1990 оны 08 дугаар сарын 05-ны өдөр.
5. Төмөрдөшийн Баярхүү, *Улаан террор: Монголын улс төрийн хэлмэгдүүлэлт*, 2009 он
6. Дэмбэрэлийн Өлзийбаатар, *Монголчууд: Хэлмэгдүүлэлтийн эрин үе*, 2007 он.
7. Дамдины Дашдаваа, "Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтэд буриад зон ертсөн нь" *Буриад судлал №1*, 2008 он.



Article

Issues in improving legal regulation the crime of genocide

ALTANGEREL Batkhuyag*

Abstract: This study examines the legal framework regulating the crime of genocide and analyzes the obligations of states to prevent and punish such acts under international criminal law. The objective of the research is to assess the effectiveness of existing international and domestic mechanisms in ensuring accountability for genocide and to evaluate their relevance to the principle of Responsibility to Protect.

The research employs doctrinal legal research method, including the interpretation of treaty provisions, customary international law, and relevant jurisprudence of international criminal tribunals. In particular, it analyzes the provisions of the Convention on the Prevention and Punishment of the Crime of Genocide and examines the jurisprudential contributions of the International Criminal Court, the International Criminal Tribunal for the Former Yugoslavia, and the International Criminal Tribunal for Rwanda in clarifying the elements of genocidal intent and state responsibility. The study also considers the incorporation of genocide into domestic criminal legislation, with particular reference to Mongolia's legal framework and scholarly debates concerning the political repression in Mongolia during 1937–1939.

The findings indicate that, although genocide is firmly established as a jus cogens norm and one of the core crimes under international law, significant gaps remain in the effective and consistent implementation of prevention obligations and in the timely invocation of international protective mechanisms. The analysis further demonstrates that strengthening domestic criminalization, enhancing judicial cooperation, and operationalizing the principle of Responsibility to Protect are essential for improving accountability and preventing future atrocities.

Accordingly, the study concludes that greater coherence between international and domestic legal frameworks is necessary to ensure the effective prosecution of genocide and the protection of fundamental human rights.

Keywords: Responsibility to Protect, genocide, international crimes, international criminal law, genocidal intent, state responsibility.

* Researcher of the Case management, information, research department of Supreme court of Mongolia.